

**ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫН ХҮЧИЛТӨРӨГЧИЙН ҮЙЛДВЭР БОЛОН
ХИЙН ХАНГАМЖИЙН СИСТЕМИЙН ХЭВИЙН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНД
ҮНЭЛГЭЭ ХИЙХ АЖЛЫН ТАЙЛАН**



Улаанбаатар хот

2022 он

НЭГ. ҮНЭЛГЭЭНИЙ ҮНДЭСЛЭЛ

Эрүүл мэндийн сайдын 2022 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 02 дугаар албан даалгаврыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд “Эрүүл мэндийн байгууллагад суурилагдсан хүчилтөрөгчийн үйлдвэрүүдийн хэвийн аюулгүй ажиллагаанд үнэлгээ хийх”, Эмнэлгийн тоног төхөөрөмжийн газрын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд “Хүчилтөрөгчийн хангамж, үйлдвэрийн өнөөгийн байдалд үнэлгээ хийх” гэсэн арга хэмжээ тус тус тусгагдсан.

Коронавируст халдвар (КОВИД-19)-ын үед хүчилтөрөгчийн эмчилгээ хийх шаардлага их байгаа тул хүчилтөрөгчийн үйлдвэр, хүчилтөрөгчийн хийн хангамжийн системийн хангамжийн хэвийн найдвартай ажиллагааг ханган ажиллах зайлшгүй шаардлагатай байна. Иймд батлагдсан хуваарийн дагуу төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллага дээр очин хүчилтөрөгчийн үйлдвэр, хүчилтөрөгчийн хийн хангамжийн системийн хэвийн, аюулгүй ажиллагаа болон Коронавируст халдвар (КОВИД-19)-ын эмчилгээний тасагт хүчилтөрөгчийн эмчилгээ хийх нөхцөлийг бүрдүүлсэн эсэхэд үнэлгээ хийх, хүчилтөрөгч хариуцан ажилладаг хүний нөөцийн мэдээллийг гаргаж, хэрэгцээ шаардлагыг тодорхойлох шаардлагатай байна.

Зорилго: Эрүүл мэндийн байгууллагуудын хүчилтөрөгчийн үйлдвэр, хийн хангамжийн системийн хэвийн, аюулгүй ажиллагаанд үнэлгээ тавьж, хүний нөөцийн мэдээллийг гарган тулгамдаж буй асуудал, хэрэгцээ шаардлагыг тодорхойлох.

Зорилт:

1. Эрүүл мэндийн байгууллагуудын хүчилтөрөгчийн үйлдвэрийн хэвийн аюулгүй ажиллагаанд үнэлгээ хийх;
2. Хүчилтөрөгчийн хий худалдан авдаг эрүүл мэндийн байгууллагуудын хүчилтөрөгчийн хангалт, нөөцөд үнэлгээ хийх;
3. Хийн хангамжийн систем, шугам хоолойн хэвийн, аюулгүй ажиллагаа болон Коронавируст халдвар (КОВИД-19)-ын эмчилгээний тасагт хүчилтөрөгчийн эмчилгээ хийх нөхцөлийг бүрдүүлсэн эсэхэд үнэлгээ хийх;
4. Хүчилтөрөгчийн асуудал хариуцсан хүний нөөцийн нэгдсэн мэдээллийг гаргах;
5. Эрүүл мэндийн байгууллагуудын тулгамдаж буй асуудал, хэрэгцээ шаардлагыг тодорхойлох.

Үйл ажиллагаа:

1. Нийслэлийн эрүүл мэндийн байгууллагууд дээр очиж, орон нутгийн эрүүл мэндийн байгууллагын холбогдох ажилтантай Мягмар гараг бүр утсаар холбогдон батлагдсан асуумжийн дагуу мэдээллийг авах;
2. Эрүүл мэндийн байгууллагуудаас авсан болон ирүүлсэн мэдээллийг нэгтгэж, тайланг боловсруулах;
3. Ажлын тайланг Эрүүл мэндийн яаманд албан бичгээр хүргүүлэх.

Хугацаа: 2022 оны 02 дугаар сарын 14-өөс 03 дугаар сарын 30-ны хооронд хийж гүйцэтгэнэ.


Хүлээгдэж буй үр дүн: Эрүүл мэндийн байгууллагуудын хүчилтөрөгчийн үйлдвэр, хийн хангамжийн системийн хэвийн, аюулгүй ажиллагаанд үнэлгээ хийж, хүний нөөцийн мэдээллийг гарган тулгамдаж буй асуудал, хэрэгцээ шаардлагыг тодорхойлж шийдвэр гаргагчдыг мэдээллээр хангасан байна.

ХОЁР. ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН

Эрүүл мэндийн сайдын 2022 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 02 дугаар албан даалгаврыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд “Эрүүл мэндийн байгууллагад суурилагдсан хүчилтөрөгчийн үйлдвэрүүдийн хэвийн аюулгүй ажиллагаанд үнэлгээ хийх”, Эмнэлгийн тоног төхөөрөмжийн газрын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд “Хүчилтөрөгчийн хангамж, үйлдвэрийн өнөөгийн байдалд үнэлгээ хийх” гэсэн арга хэмжээ тус тус заасан. Тус 2 арга хэмжээг нэгтгэн “Эрүүл мэндийн байгууллагын хүчилтөрөгчийн үйлдвэр болон хийн хангамжийн системийн хэвийн аюулгүй ажиллагаанд үнэлгээ хийх ажил”-ын удирдамж, асуумж, хуваарийг боловсруулж, 2022 оны 02 дугаар сарын 10-ны өдөр Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын дэд даргаар батлуулсан. Батлагдсан удирдамжийн дагуу хүчилтөрөгчийн үйлдвэртэй, хүчилтөрөгчийн хий худалдан авч ашигладаг нийт 40 эрүүл мэндийн байгууллага тус үнэлгээнд хамрагдсан. Эрүүл мэндийн яамны харьяа 13, бусад яамны харьяа 4, нийслэлийн эрүүл мэндийн газрын харьяа 2 буюу нийслэлийн 19 буюу эрүүл мэндийн байгууллага дээр очиж, орон нутгийн харьяа 21 эрүүл мэндийн байгууллагад удирдамж, асуумжийг цахимаар хүргүүлэн, мэдээллийг авч ажилласан.

Зорилт.1 Эрүүл мэндийн байгууллагуудын хүчилтөрөгчийн үйлдвэрийн хэвийн аюулгүй ажиллагаанд үнэлгээ хийх зорилтын хүрээнд:

Эрүүл мэндийн байгууллагын хүчилтөрөгчийн хэрэглээ жил ирэх тусам нэмэгдэж байсан тул улсын төсөв болон олон улсын байгууллагын хөрөнгө оруулалтаар 2019 оноос эхлэн 24 эрүүл мэндийн байгууллагын дэргэд 6 нэр төрлийн 25 хүчилтөрөгчийн үйлдвэр суурилагдсан байна. Эдгээр хүчилтөрөгчийн үйлдвэрийн хүчин чадал харилцан адилгүй буюу 20-ээс 75 Нм³ байна. Хүчилтөрөгчийн үйлдвэрийн хүчин чадал дэлгэрэнгүй мэдээллийг нэгдүгээр зураг, хүснэгтэд харуулав.



Зураг 1. Хүчилтөрөгчийн үйлдвэрийн ашиглалтад орсон хугацаа

Хүчилтөрөгчийн үйлдвэрийн ашиглалтанд орсон оноор ангилан үзвэл 2019 онд 5, 2020 онд 2, 2021 онд 15, 2022 онд 3 буюу Коронавируст халдвар (КОВИД-19)-ын тархалт их байсан 2021 онд хүчилтөрөгчийн үйлдвэрийн хөрөнгө оруулалт нэмэгдэж, тус онд хамгийн их хүчилтөрөгчийн үйлдвэр суурилагдсан байна.

Хүснэгт 1. Суурилагдсан хүчилтөрөгчийн үйлдвэрийн нэр төрөл, хүчин чадал

№	Үйлдвэрлэгч	Загвар	Үйлдвэрлэсэн улс	Хүчин чадал	Эрүүл мэндийн байгууллагын тоо			
					ЭМЯ-ны харьяа	Бусад яамны харьяа	НЭМГ-ын харьяа	Орон нутгийн харьяа
1	Adekom	KSO-20	БНХАУ	20Нм ³	3	3	2	2
2	CanGas	CAPO-20	БНХАУ	20Нм ³	0	0	0	9
3	CanGas	Atlas Copco	Швед	20Нм ³	0	0	0	3
4	Denair	DA-55	БНХАУ	31Нм ³	1	0	0	0
5	Oxywise	035+	БНСУ	75Нм ³	1	0	0	0
6	Livtech	Livtech	БНХАУ	20Нм ³	1	0	0	0
	Нийт				7	3	2	14
	НИЙТ				25			

Хүчилтөрөгчийн үйлдвэрийг байршлаар нь авч үзвэл Эрүүл мэндийн яамны харьяа 4, бусад яамны харьяа 3, нийслэлийн эрүүл мэндийн газрын харьяа 2, орон нутгийн харьяа 14 эрүүл мэндийн байгууллагын дэргэд суурилагдсан. Нийт 20Нм³ хүчин чадалтай 23 хүчилтөрөгчийн үйлдвэр, 31 Нм³ болон 75Нм³ хүчин чадалтай хүчилтөрөгчийн үйлдвэр тус тус 1 байна. Улсын хоёрдугаар төв эмнэлгийн үйл ажиллагаанд хамгийн өндөр буюу 75Нм³ хүчин чадалтай хүчилтөрөгчийн үйлдвэр ашиглагдаж байна. Хятад улсын CanGas болон Adekom компанид үйлдвэрлэсэн 22, бусад улсад үйлдвэрлэсэн 3 хүчилтөрөгчийн үйлдвэр байна.

Тус 25 хүчилтөрөгчийн үйлдвэрийн 7 нь гэмтэлтэй бөгөөд хүний нөөц, төсвийн дутагдал, урсгал засварыг цаг тухайд нь хийгээгүйн улмаас хүчилтөрөгчийн үйлдвэрийн гэмтэл үүсч байна. Дэлгэрэнгүй мэдээллийг хоёрдугаар хүснэгтэд харуулав.

Хүснэгт 2. Хүчилтөрөгчийн үйлдвэрт гэмтэл үүссэн шалтгаан

№	Байгууллагын нэр	Гэмтэл үүссэн шалтгаан
1	Улсын нэгдүгээр төв эмнэлэг	Генераторын тосгүй.
2	Улсын хоёрдугаар төв эмнэлэг	Филтерийн хугацаа дууссан.
3	Эх, нярайн эрүүл мэндийн үндэсний төв-2	Хүчилтөрөгчийн агууламж буурдаг.
4	Гэмтэл согог судлалын үндэсний төв	Манофорын систем хуучирсан, вакуум насос эвдэрсэн.


5	Баян-Өлгий аймгийн нэгдсэн эмнэлэг	Генераторын тос солих хугацаа болсон.
6	Завхан аймгийн нэгдсэн эмнэлэг	Хүйтний улмаас хөлдсөн. Одоогоор хэвийн горимдоо ороогүй ажиллагаа доголдсон хэвээр ажиллаж байна.
7	Увс аймгийн нэгдсэн эмнэлэг	Хатаагч эвдэрсэн.

Гэмтэл үүссэн шалтгааныг ангилвал хугацаат сэлбэг хэрэгсэл солих шаардлагатай 5, гэмтлийн шалтгааныг тодорхойлж, засварлах шаардлагатай 2 хүчилтөрөгчийн үйлдвэр байна. Мөн Коронавируст халдвар (КОВИД-19)-ын улмаас үүссэн тээвэрлэлтийн асуудлаас шалтгаалан хугацаат сэлбэг хэрэгслийг худалдан авалт хийхэд зах зээл дээр бэлэн бус, үйлдвэрлэгч байгууллагад захиалга өгөхөд 30 ба түүнээс дээш хугацаанд хүлээх шаардлага тулгарч байгаа нь түргэн, шуурхай засвар үйлчилгээ хийхэд хүндрэл үүсгэж байна.

Тэмдэглэл 1: Хүчилтөрөгчийн үйлдвэрийн хугацаат сэлбэг хэрэгсэл тендерээр болон бэлэн худалдан авалтаар олддоггүй, хүчилтөрөгчийн үйлдвэр хариуцан ажиллах чиглэлээр мэргэшсэн инженер, техникч эмнэлгүүдэд байхгүй учир хэвийн, аюулгүй ажиллагааг хангаж чаддаггүй...

Улсын хоёрдугаар төв эмнэлгийн инженер


Мөн хүчилтөрөгчийн үйлдвэрийг тасралтгүй үйл ажиллагаагаар хангахын тулд цахилгааны нөөц үүсгүүрт холбосон байх шаардлагатай. Эдгээр 25 хүчилтөрөгчийн үйлдвэрийн 9 нь цахилгааны нөөц үүсгүүрт холбогдсон, холбогдоогүй 16 байгаа бөгөөд цахилгааны нөөц үүсгүүрт холбогдоогүй нийт байгууллагын 41% нь орон нутгийн харьяа эрүүл мэндийн байгууллага байна. Дэлгэрэнгүй мэдээллийг хоёрдугаар зурагт харуулав.



Зураг 2. Цахилгааны нөөц үүсгүүрт холбосон эрүүл мэндийн байгууллагын тоо

Зорилт.2 Хүчилтөрөгчийн хий худалдан авдаг эрүүл мэндийн байгууллагуудын хүчилтөрөгчийн хангалт, нөөцөд үнэлгээ хийх зорилтын хүрээнд:


Үнэлгээнд хамрагдсан 40 эрүүл мэндийн байгууллага нийт 2019 онд 66,102, 2020 онд 82,590, 2021 онд 204,333 ширхэг хүчилтөрөгчийн хийн баллон тус тус ашигласан байна.



Зураг 3. Хүчилтөрөгчийн хийн хэрэглээний баллоны тоо

Тус онуудад хүчилтөрөгчийн хийн хэрэглээ хамгийн өндөр нь эрүүл мэндийн яамны харьяа эрүүл мэндийн байгууллагууд бөгөөд дэлгэрэнгүй мэдээллийг гуравдугаар зурагт харуулав.

Хүчилтөрөгчийн хий худалдан авч ашигладаг хүчилтөрөгчийн үйлдвэртэй 8, үйлдвэргүй 16, хүчилтөрөгчийн хийн хэрэглээ нэмэгдсэн тохиолдолд худалдан авалт хийдэг 3 эрүүл мэндийн байгууллага байна. Тус 27 эрүүл мэндийн байгууллага хүчилтөрөгчийн хий ханган нийлүүлэгч хувийн хэвшлийн "Петрохими" ХХК, "Мон-илч" ХХК, "Глобал ацетелин" ХХК, "Кислород" ХХК, "Оксигаз" ХХК, ДЭХС ТӨХК станц буюу 6 байгууллагаас хүчилтөрөгчийн хий худалдан авч байна. Худалдан авдаг хүчилтөрөгчийн хийн баллоны тоо хэрэглээнээс хамаарч хоногт эрүүл мэндийн яамны харьяа 4-60, бусад яамны харьяа 30-45, орон нутгийн харьяа эрүүл мэндийн байгууллага 10-50 ширхэг тус тус байна. Худалдан авалт хийдэг давтамжийг гуравдугаар зурагт харуулав.



Зураг.3 Эрүүл мэндийн байгууллагуудын хүчилтөрөгчийн хий худалдан авдаг давтамж

Нэг баллон хүчилтөрөгчийн хийг эрүүл мэндийн яамны харьяа эрүүл мэндийн байгууллага 7,650-аас 16,500 төгрөг, бусад яамны харьяа эрүүл мэндийн байгууллага 2,850-аас 15,400 төгрөг, нийслэлийн эрүүл мэндийн газрын харьяа

эрүүл мэндийн байгууллага 16,500 төгрөг, орон нутгийн харьяа эрүүл мэндийн байгууллага 15,400-ээс 22,000 хүртэлх төгрөгөөр тус тус худалдан авч байна.

Тэмдэглэл 2: 2021 онд эрүүл мэндийн байгууллагуудын дэргэд хүчилтөрөгчийн үйлдвэр суурилагдсанаас хойш нэг баллон хүчилтөрөгчийн хий худалдан авах үнэ буурсан...

Орон нутгийн харьяа эрүүл мэндийн байгууллагын эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженерүүд

Нийт 40 эрүүл мэндийн байгууллагын 67.5% нь хүчилтөрөгчийн хийн баллон худалдан авч байна. Эрүүл мэндийн хөгжлийн төвийн 2017 онд хийсэн Хоёр, гурав дахь шатлалын эрүүл мэндийн байгууллагад ашиглагдаж байгаа эмнэлгийн хийн хангамжийн системийн өнөөгийн байдлын судалгаанд хамрагдсан 44 байгууллагын 95% нь хүчилтөрөгчийн хийн баллон худалдаж авдаг гэсэн байдаг. Тус судалгаатай харьцуулбал хүчилтөрөгчийн үйлдвэр суурилуулсанаар хүчилтөрөгчийн хийн баллон худалдан авдаг эрүүл мэндийн байгууллага 27.5%-иар буурсанг харуулж байна.

Хүчилтөрөгчийн хий худалдан авахад түгээмэл тулгамдаж буй асуудал нь хүчилтөрөгчийн хийн баллоныг зориулалтын машинаар зөөвөрлөдөггүй, зарим тохиолдолд захиалгын тоо зөрөх, хугацаандаа ирэхгүй байх зэрэг байна. Дэлгэрэнгүй мэдээллийг гуравдугаар хүснэгтэд харуулав.

Хүснэгт.3 Ханган нийлүүлэх байгууллагаас хүчилтөрөгчийн хий худалдан авахад тулгамдаж буй асуудал


№	Эрүүл мэндийн байгууллагын нэр	Ханган нийлүүлэх байгууллагын нэр	Тухайн ханган нийлүүлэх байгууллагаас хүчилтөрөгч худалдан авахад тулгамдаж буй асуудал
1	Хүрээ Амаржих Газар	"Кислород" ХХК	Өөрийн машинаар очиж буюу зориулалтын бус машинаар очиж авдаг.
2	Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлэг	"Мон-илч" ХХК	Баталгаажилтгүй баллонтай.
3	Эх, нярайн эрүүл мэндийн үндэсний төв-2	"Мон-илч" ХХК	Хүчилтөрөгчийн хэрэглээ ихэссэн үед худалдан авалт хийдэг. Зарим тохиолдолд хугацаандаа ирдэггүй.
4	АШУҮИС-ын харьяа Монгол Японы эмнэлэг	"Петрохими" ХХК	Хугацаандаа ирдэггүй.
5	Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв	"Мон-илч" ХХК	Зарим үед захиалсан тооноос бага ирдэг.
6	Говьсүмбэр аймгийн нэгдсэн эмнэлэг	"Глобал ацетелин" ХХК	Зориулалтын зөөдөг машин байхгүй.

7	Сэлэнгэ аймгийн нэгдсэн эмнэлэг	"Глобал ацетелин" ХХК	Зориулалтын бус машинаар татан авалт хийдэг.
---	---------------------------------	-----------------------	--

Зорилт.3 Хийн хангамжийн систем, шугам хоолойн хэвийн, аюулгүй ажиллагаа болон коронавируст халдвар (ковид-19)-ын эмчилгээний тасагт хүчилтөрөгчийн эмчилгээ хийх нөхцөлийг бүрдүүлсэн эсэхэд үнэлгээ хийх зорилтын хүрээнд:

Шугам хоолойгоор ирсэн хүчилтөрөгчийн хийг өвчтөнд шууд өгч буй хэрэгслийг төгсгөвч гэнэ. Эрүүл яамны харьяа 11, бусад яамны харьяа 4, нийслэлийн эрүүл мэндийн газрын харьяа 2, орон нутгийн харьяа 18 буюу нийт 35 эрүүл мэндийн байгууллага төгсгөвчтэй ба төгсгөвчгүй эрүүл мэндийн яамны харьяа 2, орон нутгийн харьяа 3 нийт 5 эрүүл мэндийн байгууллага байна.

Коронавируст халдварын эмчилгээний тасагт өвчтөн хүлээн авч байгаа эрүүл мэндийн байгууллага 17 ба үлдсэн 23 эрүүл мэндийн байгууллага одоогийн байдлаар тус тасгийн үйл ажиллагааг буулгасан байна. Дэлгэрэнгүй мэдээллийг тавдугаар зураг, дөрөвдүгээр хүснэгтэд харуулав.



Зураг.5 Коронавируст халдварын эмчилгээний тасгийн ор болон төгсгөвчийн тоо

Хүснэгт.4 Төгсгөвчтэй болон нэмэлтээр төгсгөвч шаардлагатай эрүүл мэндийн байгууллагын тоо


№	Харьяа эрүүл мэндийн байгууллага	Төгсгөвчтэй эрүүл мэндийн байгууллагын тоо	Коронавируст халдварын эмчилгээний тасагт төгсгөвчтэй эрүүл мэндийн байгууллагын тоо	Төгсгөвч нэмэлтээр шаардлагатай эрүүл мэндийн байгууллагын тоо
1	ЭМЯ-ны харьяа	11	4	7
2	Бусад яамны харьяа	4	2	0
3	НЭМГ-ын харьяа	2	0	0

4	Орон нутгийн харьяа	18	9	17
	НИЙТ	35	15	24

*40 эрүүл мэндийн байгууллагын хүчилтөрөгчийн хийн баллон болон төгсгөвчийн дэлгэрэнгүй мэдээллийг нэгдүгээр хавсралтад оруулав.

Зорилт.4 Хүчилтөрөгчийн асуудал хариуцсан хүний нөөцийн нэгдсэн мэдээллийг гаргах зорилтын хүрээнд:

Нийт 40 эрүүл мэндийн байгууллагад хүчилтөрөгч хариуцсан инженер 32, техникч 63, операторч 32 байна. Үүний сургалтад хамрагдаж мэргэжлийн үнэмлэхтэй инженер 29, техникч 59, операторч 32 байна. Дэлгэрэнгүй мэдээллийг зургаадугаар зурагт харуулав.



Зураг.6 Хүчилтөрөгч хариуцсан ажилчидын тоо

Эрүүл мэндийн яамны харьяа 13 эрүүл мэндийн байгууллагад хүчилтөрөгч хариуцсан инженер 6, техникч 20, операторч 23 байна. Нийслэлийн эрүүл мэндийн газрын харьяа 2 эрүүл мэндийн байгууллагад хүчилтөрөгч хариуцсан инженер 3, техникч 6 ба операторч байхгүй. Орон нутгийн харьяа 21 эрүүл мэндийн байгууллагад хүчилтөрөгч хариуцсан инженер 29, техникч 63, операторч 32 байна. “Даралтат сав, хийн баллон ашиглах сургалт”-д хамрагддаггүй орон нутгийн харьяа 5 эрүүл мэндийн байгууллага байгаа бөгөөд үлдсэн 35 эрүүл мэндийн байгууллагын хүчилтөрөгч хариуцсан ажилчид жил бүр тус сургалтад хамрагддаг.



Зураг.7 Хүчилтөрөгчийн ажилчидын ажиллах ээлжийн тоо

Нэг ээлжээр ажилладаг 9, хоёр ээлжээр ажиллдаг 3, гурван ээлжээр ажилладаг 9, дөрвөн ээлжээр ажилладаг 11, ээлжээр ажилладаггүй 8 эрүүл мэндийн байгууллага байна.

Зорилт.5 Эрүүл мэндийн байгууллагуудын тулгамдаж буй асуудал, хэрэгцээ шаардлагыг тодорхойлох:

Нийтлэг тулгамдаж буй асуудал хүчилтөрөгч хариуцсан хүний нөөц, төгсгөвч болон хүчилтөрөгчийн хийн баллон нэмэлтээр шаардлагатай байна. Мөн хүчилтөрөгчийн үйлдвэрийн урсгал засвар хийгдэх хугацаа болсон, засвар хийх шаардлагатай сэлбэг, хэрэгсэл, төсөв байхгүй зэрэг байна. Дэлгэрэнгүй мэдээллийг тавдугаар хүснэгтэд харуулав.

Хүснэгт.5 Эрүүл мэндийн байгууллагуудад тулгамдаж буй асуудал

№	Байгууллагын нэр	Тулгамдаж буй асуудал
1	Өргөө Амаржих Газар	Нэмэлтээр төгсгөвч шаардлагатай.
2	Эх, нярайн эрүүл мэндийн үндэсний төв-2	Баллон бага, 14 тасагт хүрэлцээгүй.
3	АШУҮИС-ын харьяа Монгол Японы эмнэлэг	Төгсгөвчийн жийргэвч, боолт жижиг сэлбэг хэрэгслүүд шаардлагатай.
4	Говь-Алтай аймгийн нэгдсэн эмнэлэг	Хүчилтөрөгчийн баллон байрлаж байгаа өрөөг стандартад нийцүүлэх, хүчилтөрөгчийн техникчийн дутагдалтай.
5	Говьсүмбэр аймгийн нэгдсэн эмнэлэг	Баллон зөөвөрлөх жижиг тэрэг байдаггүй. Машин байхгүй тохиолдолд өөрөө үүрч зөөдөг. Мөн

		сурах хүсэлтийг өгсөн боловч одоогоор хариу байхгүй байна.
6	Дорноговь аймгийн нэгдсэн эмнэлэг	Ашиглалт, хүний нөөцийн дутагдалтай.
7	Завхан аймгийн нэгдсэн эмнэлэг	Хүний нөөц дутмаг. Хүний нөөц дутмагаас болж үйлдвэр 24 цаг ажиллахгүй байгаагаас хүйтний улиралд үйлдвэр хөлдөж доголдол үүссэн.
8	Орхон аймгийн бүсийн оношилгоо, эмчилгээний төв	Нийт баллоны тоог нэмэгдүүлэх 40л-ийн баллон 30 ширхэг, 10л-ийн баллон 10ширхэг. Редуктор болон бобровын тоог нэмэгдүүлэх. Баллоныг зөөвөрлөхөд зориулсан машинтай болох.
9	Өвөрхангай аймгийн бүсийн оношилгоо, эмчилгээний төв	Ээлжээр ажиллах ажилтан шаардлагатай, 10л баллон цэнэглэх цэнэглэгч шаардлагатай байна.
10	Өмнөговь аймгийн бүсийн оношилгоо, эмчилгээний төв	5, 10, 40л баллонуудын тоог нэмэгдүүлэх, хүчилтөрөгчийн үйлдвэрт мэргэжлийн байгууллагаар засвар үйлчилгээ хийлгэхэд өртөг өндөр, сэлбэгийн үнэ өндөр байна. Энэ хөрөнгийн асуудлыг шийдэх, нийт үнэ 29.000.000 төгрөг.
11	Сэлэнгэ аймгийн нэгдсэн эмнэлэг	Хүчилтөрөгчийн хийн хангамжийн чиглэлээр ажиллаж буй ажилчидыг зохион байгуулалттайгаар сургалтанд хамруулах, мэргэшүүлэх шаардлагатай байна.
12	Увс аймгийн нэгдсэн эмнэлэг	Баллоны хүрэлцээ муу, сургалтад хамрагдах, операторчийн тоог нэмэх.
13	Ховд аймгийн бүсийн оношилгоо, эмчилгээний төв	Төрөх, Нярай, Эмэгтэйчүүд, Халдварт, Сүрьеэгийн тасгуудад ханын систем нэн шаардлагатай байна. Баллон цэнэглэх booster-ийн хүчин чадал нэмэгдүүлэх, нөөц цахилгааны эх үүсвэр, тог тогтворжуулагч хэрэгтэй.
14	Хөвсгөл аймгийн нэгдсэн эмнэлэг	Баллон дутагдалтай 40л-ийн 20, 10л-ийн 5.
15	Хэнтий аймгийн нэгдсэн эмнэлэг	Үйлдвэртэй болох, 3 ээлжийн хүчилтөрөгчийн операторчтой болох, жил бүр сургалтанд хамрагдах.

Хүчилтөрөгчийн хийн баллон түүний дагалдах хэрэгсэл шаардлагатай 5, хүний нөөц шаардлагатай 4, төгсгөвч шаардлагатай 3, сургалтад хамруулах шаардлагатай 3 эрүүл мэндийн байгууллага байна.

ГУРАВ. ДҮГНЭЛТ

Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын дэд даргын 2022 оны 02 дугаар сарын 10-ны өдөр баталсан “Эрүүл мэндийн байгууллагын хүчилтөрөгчийн үйлдвэр болон хийн хангамжийн системийн хэвийн аюулгүй ажиллагаанд үнэлгээ хийх ажил”-ын удирдамж, хуваарийн дагуу хүчилтөрөгчийн үйлдвэртэй, хүчилтөрөгчийн хий худалдан авч ашигладаг нийт 40 эрүүл мэндийн байгууллагыг хамруулсан. Нийслэлийн 19 эрүүл мэндийн байгууллага дээр очиж, орон нутгийн харьяа 21 эрүүл мэндийн байгууллагад удирдамж, асуумжийг цахимаар хүргүүлэн мэдээллийг авч ажилласан.

Тус ажилд хамрагдсан 40 эрүүл мэндийн байгууллагаас 24 эрүүл мэндийн байгууллагын дэргэд улсын төсөв болон олон улсын байгууллагын хөрөнгө оруулалтаар 20-ээс 75 Нм³ хүчин чадалтай 6 нэр төрлийн 25 хүчилтөрөгчийн үйлдвэр суурилагдсан байна. Нийт 25 хүчилтөрөгчийн үйлдвэрийн 7 нь гэмтэлтэй байна. Гэмтэл үүссэн шалтгааныг ангилвал хугацаат сэлбэг хэрэгсэл солих шаардлагатай 5, гэмтлийн шалтгааныг тодорхойлж, засварлах шаардлагатай 2 хүчилтөрөгчийн үйлдвэр байна. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын улмаас үүссэн тээвэрлэлтийн асуудлаас шалтгаалан хугацаат сэлбэг хэрэгслийг худалдан авалт хийхэд зах зээл дээр бэлэн бус, үйлдвэрлэгч байгууллагад захиалга өгөхөд 30 ба түүнээс дээш хугацаанд хүлээх шаардлага тулгарч байгаа нь түргэн, шуурхай засвар үйлчилгээ хийхэд хүндрэл үүсгэж байна. Мөн 2021 онд суурилагдсан 15 хүчилтөрөгчийн үйлдвэрийн баталгаат хугацаа дуусахад хугацаат сэлбэг хэрэгслийн бэлэн байдал, нөөцийг бүрдүүлэх шаардлагатай байна. Завхан аймгийн нэгдсэн эмнэлгийн гэмтэл үүссэн шалтгаанаас харахад Монгол улсын цаг агаарын нөхцөлд тохирсон хүчилтөрөгчийн үйлдвэрийн агаар сэлгэлт, хөргөлт, халаалтын асуудлыг шийдвэрлэх шаардлагатай байна.

Нийт хүчилтөрөгчийн үйлдвэрийн 64% буюу 16 нь цахилгааны нөөц үүсгүүрт холбогдоогүй байна. Цахилгааны доголдол, тасралт өндөр орон нутгийн харьяа эрүүл мэндийн байгууллагад ашиглагдаж байгаа хүчилтөрөгчийн үйлдвэрийн 41% холбогдоогүй байгаа нь цахилгааны доголдол, тасралтаас үүдэн гэмтэл үүсэх, эмнэлгийн тусламж үйлчилгээнд ашиглагдаж буй хүчилтөрөгчийн хий тасалдах эрсдэлтэй байна.

Хүчилтөрөгчийн хий худалдан авч ашигладаг хүчилтөрөгчийн үйлдвэртэй 8, үйлдвэргүй 16, хүчилтөрөгчийн хийн хэрэглээ нэмэгдсэн тохиолдолд худалдан

авалт хийдэг 3 эрүүл мэндийн байгууллага байна. Тус 27 эрүүл мэндийн байгууллага хүчилтөрөгчийн хий ханган нийлүүлэгч хувийн хэвшлийн "Петрохими" ХХК, "Мон-илч" ХХК, "Глобал ацетелин" ХХК, "Кислород" ХХК, "Оксигаз" ХХК, ДЭХС ТӨХК станц буюу 6 байгууллагаас хүчилтөрөгчийн хий худалдан авч байна. Худалдан авдаг хүчилтөрөгчийн хийн баллоны тоо хэрэглээнээс хамаарч хоногт эрүүл мэндийн яамны харьяа 4-60, бусад яамны харьяа 30-45, орон нутгийн харьяа эрүүл мэндийн байгууллага 10-50 ширхэг тус тус байна. Нийт 40 эрүүл мэндийн байгууллагын 67.5% нь хүчилтөрөгчийн хийн баллон худалдан авч байна. Эрүүл мэндийн хөгжлийн төвийн 2017 онд хийсэн Хоёр, гурав дахь шатлалын эрүүл мэндийн байгууллагад ашиглагдаж байгаа эмнэлгийн хийн хангамжийн системийн өнөөгийн байдлын судалгаанд хамрагдсан 44 байгууллагын 95% нь хүчилтөрөгчийн хийн баллон худалдаж авдаг гэсэн байдаг. Тус судалгаатай харьцуулбал хүчилтөрөгчийн үйлдвэр суурилуулсанаар хүчилтөрөгчийн хийн баллон худалдан авдаг эрүүл мэндийн байгууллага 27.5%-иар буурсанг харуулж байна.

Эрүүл мэндийн яамны харьяа 13 эрүүл мэндийн байгууллагад хүчилтөрөгч хариуцсан инженер 6, техникч 20, операторч 23 байна. Нийслэлийн эрүүл мэндийн газрын харьяа 2 эрүүл мэндийн байгууллагад хүчилтөрөгч хариуцсан инженер 3, техникч 6 ба операторч байхгүй. Орон нутгийн харьяа 21 эрүүл мэндийн байгууллагад хүчилтөрөгч хариуцсан инженер 29, техникч 63, операторч 32 байна. "Даралтат сав, хийн баллон ашиглах сургалт"-д хамрагддаггүй орон нутгийн харьяа 5 эрүүл мэндийн байгууллага байгаа бөгөөд үлдсэн 35 эрүүл мэндийн байгууллагын хүчилтөрөгч хариуцсан ажилчид жил бүр тус сургалтад хамрагддаг.

Үнэлгээнд хамрагдсан 40 эрүүл мэндийн байгууллагад нийтлэг тулгамдаж буй асуудал нь хүчилтөрөгчийн хийн баллон түүний дагалдах хэрэгсэл шаардлагатай 5, хүний нөөц шаардлагатай 4, төгсгөвч шаардлагатай 3, сургалтад хамруулах шаардлагатай 3 эрүүл мэндийн байгууллага байна.

Цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ:

1. Орон нутгийн эрүүл мэндийн байгууллагуудад хүчилтөрөгч хариуцсан ажилтны тоог нэмэгдүүлж, холбогдох мэргэшүүлэх сургалтыг давтамжтайгаар зохион байгуулах.
2. Хүчилтөрөгчийн шугам хоолой, үйлдвэрийн стандартыг боловсруулах.
3. Хүчилтөрөгчийн үйлдвэрийн хугацаат сэлбэгийн бэлэн байдал, нөөцийг бүрдүүлэх.

4. Хүчилтөрөгчийн хий худалдан авч ашигладаг эрүүл мэндийн байгууллагууд хүчилтөрөгчийн хий зөөвөрлөх зориулалтын машиныг шийдвэрлэх, хувийн хэвшлийн хүчилтөрөгчийн үйлдвэрийн тээвэрлэлтэд үнэлгээ хийх.

Хавсралт 1

Хүснэгт 1. Эрүүл мэндийн байгууллагын дэргэд суурилагдсан хүчилтөрөгчийн бэсрэг үйлдвэрийн мэдээлэл

№	Байгууллагын нэр	Хүчилтөрөгчийн үйлдвэртэй эсэх	Үйлдвэрийн марк, модель	Үйлдвэрийн хүчин чадал	Үйлдвэрийн ашиглалтад орсон хугацаа	Нийт төгсгөвчийн тоо	Үйлдвэр хэвийн ажиллагаатай эсэх	Гэмтэлтэй бол гэмтлийн шалтгаан
ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ ХАРЬЯА ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГА								
1	Халдварт өвчин судлалын үндэсний төв	тийм	Adekom KSO-20	20нм3	2021.05.05	183	тийм	-
2	Хавдар судлалын үндэсний төв	үгүй	-	-	-	60	-	-
3	Гэмтэл согог судлалын үндэсний төв	тийм	Livtech 21	20нм3	2022.03.12	55	тийм	Манофорын систем шинэчлэх, вакуум насос солих шаардлагатай.
4	Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв	үгүй	-	-	-	150	-	-
5	Улсын гуравдугаар төв эмнэлэг	тийм	Adekom KSO-20	20нм3	2021	284	тийм	-
6	Хүрээ Амаржих Газар	үгүй	-	-	-	0	-	-
7	Эх, нярайн эрүүл мэндийн үндэсний төв-2	тийм	Adekom KSO-20	20нм3	2021.05	210	үгүй	Концентраци буурдаг, мотор нэг нь доголддог.
8	Амгалан Амаржих Газар	үгүй	-	-	-	143	-	-
9	Арьс өвчин судлалын үндэсний төв	үгүй	-	-	-	0	-	-
10	Улсын нэгдүгээр төв эмнэлэг	тийм	Denair DA-55	31нм3	2019	118	үгүй	Генераторын тосгүй, солих шаардлагатай.
11	Өргөө Амаржих Газар	үгүй	-	-	-	118	-	-

12	Улсын хоёрдугаар төв эмнэлэг	тийм	Охуwise 035+	75нм3	2019	251	үгүй	Филтерийн хугацаа дууссан, солих шаардлагатай.
13	Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв	үгүй	-	-	-	14	-	-
БУСАД ЯАМНЫ ХАРЬЯА ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГА								
14	МҮИС-ийн харьяа Универсал Мед эмнэлэг	тийм	Adekom KSO-20	20нм3	2022.01.17	266	тийм	-
15	АШУҮИС-ын харьяа Монгол Японы эмнэлэг	тийм	Adekom KSO-20	20нм3	2021.08	166	тийм	-
16	Цэргийн төв эмнэлэг	үгүй	-	-	-	134	-	-
17	Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлэг	үгүй	-	-	-	96	-	-
НИЙСЛЭЛИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ХАРЬЯА ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГА								
18	Баянгол дүүргийн эрүүл мэндийн төв	тийм	Adekom KSO-20	20нм3	2021	35	тийм	-
19	Сонгинохайрхан дүүргийн нэгдсэн эмнэлэг	тийм	Adekom KSO-20	20нм3	2021.05.12	100	тийм	-
ОРОН НУТГИЙН ХАРЬЯА ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГА								
20	Архангай аймгийн нэгдсэн эмнэлэг	тийм	CanGas CAPO-20	20нм3	2021.1	63	тийм	-
21	Баян-Өлгий аймгийн нэгдсэн эмнэлэг	тийм	CanGas CAPO-20	20нм3	2021.08	45	тийм	Генераторын тос солих шаардлагатай.
22	Баянхонгор аймгийн нэгдсэн эмнэлэг	тийм	CanGas CAPO-20	20нм3	2021.07.25	30	тийм	-
23	Булган аймгийн нэгдсэн эмнэлэг	тийм	CanGas CAPO-20	20нм3	2021.07	35	тийм	-
24	Говь-Алтай аймгийн нэгдсэн эмнэлэг	тийм	CanGas CAPO-20	20нм3	2021.06	48	тийм	-

25	Дархан-Уул аймгийн нэгдсэн эмнэлэг	тийм	Adekom KSO-20	20нм3	2021.07	68	тийм	-
26	Говьсүмбэр аймгийн нэгдсэн эмнэлэг	үгүй	-	-	-	-	-	-
27	Дорноговь аймгийн нэгдсэн эмнэлэг	үгүй	-	-	-	4	-	-
28	Дорнод аймгийн бүсийн оношилгоо, эмчилгээний төв	үгүй	-	-	-	0	-	-
29	Завхан аймгийн нэгдсэн эмнэлэг	тийм	CanGas CAPO-20	20нм3	2021.08.02	51	үгүй	Хүйтний улмаас хөлдсөн. Одоогоор хэвийн горимдоо ороогүй ажиллагаа доголдсон хэвээр ажиллаж байна.
30	Орхон аймгийн бүсийн оношилгоо, эмчилгээний төв	тийм	CanGas CAPO-20	20нм3	2021.09.19	65	тийм	-
31	Өвөрхангай аймгийн бүсийн оношилгоо, эмчилгээний төв	тийм	KC3708E T	20нм3	2019	28	тийм	-
32	Өмнөговь аймгийн бүсийн оношилгоо, эмчилгээний төв	тийм	Adekom KSO-20	20нм3	2019.12	37	тийм	-
33	Сэлэнгэ аймгийн нэгдсэн эмнэлэг	тийм	CanGas CAPO-20	20нм3	2020.11	67	тийм	-
34	Увс аймгийн нэгдсэн эмнэлэг	тийм	KC3708E T	20нм3	2020.11	57	үгүй	Хатаагч ажиллахгүй, солих шаардлагатай.
35	Ховд аймгийн бүсийн оношилгоо, эмчилгээний төв	тийм	Atlascorp o	20нм3	2019	53	тийм	-

36	Хөвсгөл аймгийн нэгдсэн эмнэлэг	тийм	CanGas CAPO-20	20нм3	2021.08	55	тийм	-
37	Дундговь аймгийн нэгдсэн эмнэлэг	үгүй	-	-	-	4	-	-
38	Сүхбаатар аймгийн нэгдсэн эмнэлэг	үгүй	-	-	-	13	-	-
39	Төв аймгийн нэгдсэн эмнэлэг	үгүй	-	-	-	25	-	-
40	Хэнтий аймгийн нэгдсэн эмнэлэг	үгүй	-	-	-		-	-

Хавсралт 2

Хүснэгт 2. Хүчилтөрөгч худалдан авдаг эрүүл мэндийн байгууллагуудын мэдээлэл

№	Байгууллагын нэр	Хүчилтөрөгч худалдан авдаг эсэх	Хүчилтөрөгч худалдан авдаг ханган нийлүүлэх байгууллагын нэр	Хүчилтөрөгч татан авах хугацаа	Нэг баллон хүчилтөрөгч худалдан авдаг үнэ	Тухайн ханган нийлүүлэх байгууллагатай хийсэн гэрээний дуусах хугацаа	Тухайн ханган нийлүүлэх байгууллагаас хүчилтөрөгч татан авахад хүндрэлтэй асуудал байгаа эсэх
ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ ХАРЬЯА ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГА							
1	Халдварт өвчин судлалын үндэсний төв	тийм	Тухай бүр тендер зарлан гэрээ байгуулдаг	Хэрэгцээнээс хамаарч	16,500	Одоогоор гэрээ хийгээгүй байгаа	-
2	Хавдар судлалын үндэсний төв	тийм	"Петрохими" ХХК	Өдөрт 1 удаа	15,400	2022 оны 03 сар	-
3	Гэмтэл согог судлалын үндэсний төв	үгүй	-	-	-	-	-
4	Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв	тийм	"Мон-илч" ХХК	Өдөрт 1 удаа	7,650	-	-
5	Улсын гуравдугаар төв эмнэлэг	тийм	"Глобал ацетелин" ХХК	7 хоногт 1	11,800	2022.12.31	-
6	Хүрээ Амаржих Газар	тийм	"Кислород" ХХК	7 хоногт 1	15,400	2022.05	Өөрийн машинаар очиж авдаг.
7	Эх, нярайн эрүүл мэндийн үндэсний төв-2	үгүй	-	-	-	-	Хугацаандаа ирдэггүй.
8	Амгалан Амаржих Газар	тийм	"Петрохими" ХХК	7 хоногт 3 удаа	12,100	2022	-
9	Арьс өвчин судлалын үндэсний төв	тийм	"Глобал ацетелин" ХХК	0	16,500	2022	-
10	Улсын нэгдүгээр төв эмнэлэг	тийм	"Мон-илч" ХХК	Өдөрт 1 удаа	16,500	2022	-
11	Өргөө Амаржих Газар	тийм	"Оксигаз" ХХК	7 хоногт 2 удаа	11,450	2022.04	-
12	Улсын хоёрдугаар төв эмнэлэг	тийм	"Мон-илч" ХХК	Өдөрт 1 удаа	9,660	2022.04	-

13	Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв	тийм	"Мон-илч" ХХК	7 хоногт 2 удаа	16,500	2022	Зарим үед захиалсан тооноос бага ирдэг
БУСАД ЯАМНЫ ХАРЬЯА ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГА							
14	МҮИС-ийн харьяа Универсал Мед эмнэлэг	үгүй	-	-	-	-	-
15	АШУҮИС-ын харьяа Монгол Японы эмнэлэг	тийм	"Петрохими" ХХК	7 хоногт 1 удаа	15,400	2022.12	Хугацаандаа ирдэггүй
16	Цэргийн төв эмнэлэг	тийм	"Мон-илч" ХХК	7 хоногт 3 удаа	15,400	2022	-
17	Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлэг	тийм	"Мон-илч" ХХК	7 хоногт 2	2,850	2022.09	Баталгаажилтгүй баллоноор тээвэрлэлт хийдэг.
НИЙСЛЭЛИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ХАРЬЯА ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГА							
18	Баянгол дүүргийн эрүүл мэндийн төв	тийм	"Мон-илч" ХХК	0	16,500	-	-
19	Сонгинохайрхан дүүргийн нэгдсэн эмнэлэг	тийм	Глобал ацетилин	Өдөрт 1 удаа	16,500	2023	-
ОРОН НУТГИЙН ХАРЬЯА ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГА							
20	Архангай аймгийн нэгдсэн эмнэлэг	үгүй	-	-	-	-	-
21	Баян-Өлгий аймгийн нэгдсэн эмнэлэг	үгүй	-	-	-	-	-
22	Баянхонгор аймгийн нэгдсэн эмнэлэг	үгүй	-	-	-	-	-
23	Булган аймгийн нэгдсэн эмнэлэг	үгүй	-	-	-	дууссан	-
24	Говь-Алтай аймгийн нэгдсэн эмнэлэг	үгүй	-	-	-	-	-
25	Дархан-Уул аймгийн нэгдсэн эмнэлэг	үгүй	-	-	-	-	-
26	Говьсүмбэр аймгийн нэгдсэн эмнэлэг	тийм	"Глобал ацетелин" ХХК	14 хоногт 1 удаа. Тухайн сарын хэрэглээнээс	16,500	2022.07.01	Зориулалтын зөөдөг машин байхгүй.

				хамаараад тогтсон хугацаа байхгүй			
27	Дорноговь аймгийн нэгдсэн эмнэлэг	тийм	"Петрохими" ХХК	7 хоногт 1 удаа	16,500	2022	-
28	Дорнод аймгийн бүсийн оношилгоо, эмчилгээний төв	тийм	Станцаас- ДЭХС ТӨХК	Өдөрт 1 удаа	16,500	2022	-
29	Завхан аймгийн нэгдсэн эмнэлэг	үгүй	-	-	-	-	-
30	Орхон аймгийн бүсийн оношилгоо, эмчилгээний төв	үгүй	-	-	-	-	-
31	Өвөрхангай аймгийн бүсийн оношилгоо, эмчилгээний төв	үгүй	-	-	-	-	-
32	Өмнөговь аймгийн бүсийн оношилгоо, эмчилгээний төв	үгүй	-	-	-	-	-
33	Сэлэнгэ аймгийн нэгдсэн эмнэлэг	тийм	"Глобал ацетелин" ХХК	14 хоногт 1 удаа. Тухайн сарын хэрэглээнээс хамаараад тогтсон хугацаа байхгүй	22,000	2022.09	Зориулалтын бус машинаар татан авдаг
34	Увс аймгийн нэгдсэн эмнэлэг	үгүй	-	-	-	-	-
35	Ховд аймгийн бүсийн оношилгоо, эмчилгээний төв	үгүй	-	-	-	-	-
36	Хөвсгөл аймгийн нэгдсэн эмнэлэг	үгүй	-	-	-	-	-
37	Дундговь аймгийн нэгдсэн эмнэлэг	тийм	Мон-Илч ХХК	Өдөрт 1 удаа	16,400	2022	Байхгүй.
38	Сүхбаатар аймгийн нэгдсэн эмнэлэг	тийм	Петрохими ХХК	Өдөрт 1 удаа	15,400	2022	Байхгүй.

39	Төв аймгийн нэгдсэн эмнэлэг	тийм	Петрохими ХХК	7 хоногт 1 удаа	15,400	2022.12	Байхгүй.
40	Хэнтий аймгийн нэгдсэн эмнэлэг	тийм	"Кислород" ХХК	7 хоног 1 удаа	16,500	2022.02.28	Байхгүй.

Хавсралт 2.1

Хүснэгт 3. Хүчилтөрөгч худалдан авдаг эрүүл мэндийн байгууллагуудын мэдээлэл

№	Байгууллагын нэр	Байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй баллоны тоо			Нийт баллоны тоо			Хүчилтөрөгч ханган нийлүүлэх байгууллагаас нэмэлтээр авдаг баллоны тоо	Нийт хүчилтөрөгчийн өдрийн хэрэглээ /баллоны тоо/	Хэрэглэсэн хүчилтөрөгч /баллоны тоогоор		
		5л	10л	40л	5л	10л	40л			2019 он	2020 он	2021 он
ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ ХАРЬЯА ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГА												
1	Халдварт өвчин судлалын үндэсний төв	6	4	30	6	4	30	0	9	100	120	400
2	Хавдар судлалын үндэсний төв	2	2	30	2	2	30	45	40	700	810	8000
3	Гэмтэл согог судлалын үндэсний төв	24	10	48	24	10	48	0	0	0	0	2100
4	Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв	35	20	112	35	20	112	60	60	6000	7300	20000
5	Улсын гуравдугаар төв эмнэлэг	0	35	102	0	35	102	60	2	0	0	18000
6	Хүрээ Амаржих Газар	0	6	22	0	6	22	5	3	400	500	700
7	Эх, нярайн эрүүл мэндийн үндэсний төв-2	3	16	48	3	6	48	–	–	0	0	0
8	Амгалан Амаржих Газар	2	2	30	2	2	30	20	8	1400	1500	2920
9	Арьс өвчин судлалын үндэсний төв	0	1	11	0	1	11	0	0	200	200	1000
10	Улсын нэгдүгээр төв эмнэлэг	8	10	70	8	10	70	30	30	9000	9000	10950
11	Өргөө Амаржих Газар	2	3	57	2	3	57	35	15	1000	1000	2400
12	Улсын хоёрдугаар төв эмнэлэг	5	7	26	5	7	26	45	45	8000	9000	10220
13	Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв	0	5	4	0	5	4	4	2	500	500	900

	Нийт	87	121	590	87	106	586	304	212	27300	29930	77590
БУСАД ЯАМНЫ ХАРЬЯА ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГА												
14	МҮИС-ийн харьяа Юниверсал Мед эмнэлэг	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
15	АШУУИС-ын харьяа Монгол Японы эмнэлэг	3	16	48	3	16	48	40	15	0	0	0
16	Цэргийн төв эмнэлэг	0	30	120	0	30	120	45	45	5000	5400	16425
17	Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлэг	2	2	27	2	2	27	30	10	10000	20000	20000
	Нийт	5	48	195	5	48	195	115	70	15000	25400	36425
НИЙСЛЭЛИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ХАРЬЯА ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГА												
18	Баянгол дүүргийн эрүүл мэндийн төв	2	16	38	2	16	38	0	10	4000	4000	10950
19	Сонгинохайрхан дүүргийн нэгдсэн эмнэлэг	7	11	80	7	11	80	0	2	30	30	3500
	Нийт	9	27	118	9	27	118	0	12	4030	4030	14450
ОРОН НУТГИЙН ХАРЬЯА ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГА												
20	Архангай аймгийн нэгдсэн эмнэлэг	0	2	33	0	2	33	0	6	200	200	528
21	Баян-Өлгий аймгийн нэгдсэн эмнэлэг	0	4	25	0	4	25	0	5	700	800	2000
22	Баянхонгор аймгийн нэгдсэн эмнэлэг	6	4	30	6	4	30	0	10	100	120	400
23	Булган аймгийн нэгдсэн эмнэлэг	0	4	25	0	4	25	0	9	90	100	1040
24	Говь-Алтай аймгийн нэгдсэн эмнэлэг	5	1	23	5	1	23	0	18	75	93	1170
25	Дархан-Уул аймгийн нэгдсэн эмнэлэг	0	0	65	0	0	65	0	80	8000	9000	18250
26	Говьсүмбэр аймгийн нэгдсэн эмнэлэг	5	2	50	5	2	50	22	8	12	100	528
27	Дорноговь аймгийн нэгдсэн эмнэлэг	6	1	65	6	1	65	40	4	500	600	2100

28	Дорнод аймгийн бүсийн оношилгоо, эмчилгээний төв	5	5	0	5	5	0	15	15	1500	2200	7000
29	Завхан аймгийн нэгдсэн эмнэлэг	0	2	15	0	2	15	0	5	150	200	904
30	Орхон аймгийн бүсийн оношилгоо, эмчилгээний төв	0	4	23	0	4	43	0	14	2247	1822	3988
31	Өвөрхангай аймгийн бүсийн оношилгоо, эмчилгээний төв	2	2	17	2	4	17	0	8	0	0	1000
32	Өмнөговь аймгийн бүсийн оношилгоо, эмчилгээний төв	0	4	18	0	4	18	0	9	220	250	4680
33	Сэлэнгэ аймгийн нэгдсэн эмнэлэг	1	3	18	1	3	18	46	30	800	900	1895
34	Увс аймгийн нэгдсэн эмнэлэг	2	2	30	2	2	30	0	10	210	111	2926
35	Ховд аймгийн бүсийн оношилгоо, эмчилгээний төв	10	4	60	10	4	60	0	6	353	607	2573
36	Хөвсгөл аймгийн нэгдсэн эмнэлэг	4	2	23	4	2	23	0	5	700	1500	2900
37	Дундговь аймгийн нэгдсэн эмнэлэг	0	0	34	0	0	34	10	10	1500	2000	6570
38	Сүхбаатар аймгийн нэгдсэн эмнэлэг	2	2	9	2	2	9	12	12	800	1000	2000
39	Төв аймгийн нэгдсэн эмнэлэг	0	3	15	0	3	15	50	7	1500	1500	12000
40	Хэнтий аймгийн нэгдсэн эмнэлэг	1	1	63	1	1	63	0	6	115	127	1416
	Нийт	49	52	641	49	54	661	195	277	19772	23230	75868
	НИЙТ	150	248	1544	150	235	1560	614	571	66102	82590	204333

Хавсралт 3

Хүснэгт 4. Хүчилтөрөгчийн хийн хангамжийг хариуцсан хүний нөөцийн мэдээлэл

№	Байгууллагын нэр	Ажиллах ээлжийн тоо	Хүний нөөц						Сургалтад жил бүр хамруулдаг эсэх
			Хариуцсан инженерийн тоо	Мэргэжлийн үнэмлэхтэй эсэх (байгаа тоо)	Хариуцсан техникчийн тоо	Мэргэжлийн үнэмлэхтэй эсэх (байгаа тоо)	Хариуцсан операторчийн тоо	Мэргэжлийн үнэмлэхтэй эсэх (байгаа тоо)	
ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ ХАРЬЯА ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГА									
1	Халдварт өвчин судлалын үндэсний төв	4	1	1	3	3	3	3	тийм
2	Хавдар судлалын үндэсний төв	2	0	0	2	2	0	0	тийм
3	Гэмтэл согог судлалын үндэсний төв	4	1	0	0	0	4	4	тийм
4	Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв	4	0	0	1	1	8	8	тийм
5	Улсын гуравдугаар төв эмнэлэг	4	0	0	0	0	5	5	тийм
6	Хүрээ Амаржих Газар	1	0	0	1	1	0	0	тийм
7	Эх, нярайн эрүүл мэндийн үндэсний төв-2	0	0	0	1	1	0	0	тийм
8	Амгалан Амаржих Газар	3	1	0	3	3	0	0	тийм
9	Арьс өвчин судлалын үндэсний төв	1	0	0	1	1	0	0	тийм
10	Улсын нэгдүгээр төв эмнэлэг	4	1	1	4	4	0	0	тийм
11	Өргөө Амаржих Газар	3	1	0	0	0	3	3	тийм
12	Улсын хоёрдугаар төв эмнэлэг	3	1	1	3	3	0	0	тийм
13	Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв	1	0	0	1	1	0	0	тийм
	Нийт	34	6	3	20	20	23	23	
БУСАД ЯАМНЫ ХАРЬЯА ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГА									
14	МҮИС-ийн харьяа Универсал Мед эмнэлэг	0	0	0	0	0	0	0	үгүй
15	АШУҮИС-ын харьяа Монгол Японы эмнэлэг	4	1	1	3	3	0	0	тийм
16	Цэргийн төв эмнэлэг	4	2	2	2	2	0	0	тийм
17	Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлэг	0	0	0	1	1	0	0	тийм
	Нийт	8	3	3	6	6	0	0	
НИЙСЛЭЛИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ХАРЬЯА ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГА									
18	Баянгол дүүргийн эрүүл мэндийн төв	0	1	1	1	0	0	0	тийм
19	Сонгинохайрхан дүүргийн нэгдсэн эмнэлэг	3	0	0	3	3	0	0	тийм
	Нийт	3	1	1	4	3	0	0	

ОРОН НУТГИЙН ХАРЬЯА ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГА									
20	Архангай аймгийн нэгдсэн эмнэлэг	4	1	1	4	4	0	0	тийм
21	Баян-Өлгий аймгийн нэгдсэн эмнэлэг	3	2	2	3	3	0	0	тийм
22	Баянхонгор аймгийн нэгдсэн эмнэлэг	4	1	1	3	3	3	3	тийм
23	Булган аймгийн нэгдсэн эмнэлэг	0	1	4	0	0	0	0	тийм
24	Говь-Алтай аймгийн нэгдсэн эмнэлэг	3	1	1	3	3	0	0	тийм
25	Дархан-Уул аймгийн нэгдсэн эмнэлэг	3	1	1	2	2	0	0	тийм
26	Говьсүмбэр аймгийн нэгдсэн эмнэлэг	1	1	0	1	0	0	0	тийм
27	Дорноговь аймгийн нэгдсэн эмнэлэг	3	2	2	1	1	0	0	тийм
28	Дорнод аймгийн бүсийн оношилгоо, эмчилгээний төв	2	1	1	1	1	0	0	тийм
29	Завхан аймгийн нэгдсэн эмнэлэг	0	1	1	1	0	0	0	үгүй
30	Орхон аймгийн бүсийн оношилгоо, эмчилгээний төв	3	1	1	1	1	1	1	тийм
31	Өвөрхангай аймгийн бүсийн оношилгоо, эмчилгээний төв	0	1	0	0	0	0	0	үгүй
32	Өмнөговь аймгийн бүсийн оношилгоо, эмчилгээний төв	1	1	1	0	1	0	0	тийм
33	Сэлэнгэ аймгийн нэгдсэн эмнэлэг	1	0	0	1	0	0	0	үгүй
34	Увс аймгийн нэгдсэн эмнэлэг	1	0	0	1	0	0	0	үгүй
35	Ховд аймгийн бүсийн оношилгоо, эмчилгээний төв	4	1	4	4	4	4	4	тийм
36	Хөвсгөл аймгийн нэгдсэн эмнэлэг	4	1	1	4	4	0	0	тийм
37	Дундговь аймгийн нэгдсэн эмнэлэг	1	0	0	1	1	0	0	тийм
38	Сүхбаатар аймгийн нэгдсэн эмнэлэг	2	1	1	1	1	0	0	тийм
39	Төв аймгийн нэгдсэн эмнэлэг	1	0	0	1	1	0	0	тийм
40	Хэнтий аймгийн нэгдсэн эмнэлэг	0	0	0	0	0	1	1	үгүй
	Нийт	41	22	22	33	30	9	9	
	НИЙТ	86	32	29	63	59	32	32	